



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ч.ЛОДОЙСАМБУУ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.09.17 № ХЯТ/2543
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн хэрэгжилт болон Улсын Их Хурлын гишүүдээс тойргийн хөрөнгө оруулалтад санал авсан талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Асуулгын хариу болон төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхтэй холбогдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн чиглэл, зөвлөмж, аргачлалын хуулбар, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ийн төлөвлөлтийн гарын авлагыг хавсаргав.

Хавсралт 00 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000255015070

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ч.ЛОДОЙСАМБУУГААС МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1-5 болон 8-ын хүрээнд нэгтгэсэн хариу:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар, 2023 оны 137 дугаар болон А/264 дүгээр тушаалуудаар баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгохтой холбоотой журам болон аргачлалуудын дагуу, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр хэрэгжүүлж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэгт заасан дараах эрэмбийг баримталдаг:

- 1.шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;
- 2.их засвар, засвар арчлалтын төсөл, арга хэмжээ;
- 3.шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ.

Дээр дурдсаны дагуу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд өмнө нь эхлүүлсэн буюу хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах асуудлыг тэргүүнд эрэмбэлдэг бол шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайд хууль, журамд заасан цаглабрын дагуу иргэдээс санал авах, сум, дүүрэг, аймаг, нийслэлээс хэрэгцээ шаардлага бүхий төсөл, арга хэмжээгээ төлөвлөх, нийт ирүүлсэн саналыг төсвийн ерөнхийлөн захирагч нар эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэж, эрэмбэлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх буюу дараах цаглабар, шаардлага болон шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөж байна. Үүнд:

1.Цаглабар:

Үе шат	Хэрэгжүүлэх процесс	Хугацаа
Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох	Сум, дүүрэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналын мэдээллийг цахим системд бүрэн оруулж, Аргачлал 2, 3-ын дагуу үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, шалгуур хангасан төслийн санал, жагсаалтыг аймаг, нийслэлд хүргүүлнэ.	Жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны дотор
	Аймаг, нийслэл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналын мэдээллийг цахим системд бүрэн оруулж, Аргачлал 2, 3-ын дагуу үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, шалгуур хангасан төслийн санал, жагсаалтыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ.	Жил бүрийн 06 дугаар сарын 25-ны дотор
	Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналын мэдээллийг цахим системд бүрэн оруулж, Аргачлал 2, 3-ын дагуу үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, шалгуур хангасан тухайн салбарт	Жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор

	хэрэгжүүлэх нийт төслийн санал, жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлнэ.	
	Сангийн яам ирүүлсэн төслүүдийн үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн оноог хянаж, шаардлагатай тохиолдолд оноог засварлан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгах нэгдсэн жагсаалтыг боловсруулна.	Жил бүрийн 08 дүгээр сарын 25-ны дотор

2. Шаардлага болон шалгуур үзүүлэлт:

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2} дахь хэсэгт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх; барилга байгууламжийн хувьд зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх; техник, эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх; урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх; тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх; олон нийтээр хэлэлцүүлсэн байх гэж тодорхой заасан.

Мөн уг хуулийн 29^{1.4} дэх хэсэгт төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хэрэгжүүлэхээр заасан бөгөөд холбогдох аргачлалын дагуу цахим системээр төсөл тус бүрд дараах 10 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч, эрэмбэлдэг болно.

Үе шат	Шалгуур үзүүлэлт	Төсвийн ерөнхийлөн захирагч			Сангийн яам		
		Оноо	Жин	Дүн	Оноо	Жин	Дүн
Төслийг үнэлэх, сонгох эрэмбэлэх	I Бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх	5	1.5	7.5	5	1.5	7.5
	II Олон нийтийн санал авсан эсэх	5	2	10.0	5	2.0	10.0
	III Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	IV Төслийн хүчин чадлын ашиглалт	5	1.5	7.5	5	1.5	7.5
	V Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх	5	2	10	5	2	10
	VI Төслийн нийт зардлыг бүрэн тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	VII Төсөлтэй холбоотой ашиглалтын хугацааны зардал, түүнийг санхүүжүүлэх санал	5	1	5	5	1	5
	VIII Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл	5	1	5	5	1	5
	IX Төслийн зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн эсэх	5	2.5	12.5	5	2.5	12.5
	X Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалт эсэх	5	2.5	12.5	5	2.5	12.5
Дүн:		100.0			100.0		

Төсвийн ерөнхийлөн захирагч нар 2026 оны төсвийн төсөлд тусгуулахаар нийт 1712 төсөл, арга хэмжээг дээрх цаглабар, шаардлага болон шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөсөн бөгөөд эдгээр төсөл, арга хэмжээний мэдээллийг www.publicinvestment.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж, иргэдийн саналыг авсан болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтад “хууль тогтоомжийн талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг судлан хариу өгөх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах” гэж, 8.1.15 дахь заалтад “иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан хариу өгөх, эсхүл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж энэ тухай хариу мэдэгдэх” гэж тус тус заасан бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ санаачлах эрх нь Улсын Их Хурлын гишүүнд нээлттэй боловч Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлд тусгах талаар тусгайлсан зохицуулалт Төсвийн тухай хуульд байхгүй болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүд тухайн салбар, орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, салбарын бодлого, хууль, журмын шаардлагад нийцүүлэн ирүүлэх боломжтой. Харин санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Улсын Их Хурлын гишүүдээс санал авах нь хууль, журмын хувьд боломжгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Тус хуульд урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Монгол Улсын Их Хурлаас тухай бүр баталж, түүнд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх талаар тусгайлан зохицуулсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг” ойлгохоор заасан бөгөөд Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг тогтоох талаар, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг бэлтгэх талаар тус тус заасан.

Төсвийн хөрөнгө оруулалт нь үр ашиг, ач холбогдол, эрэлт хэрэгцээг харгалзан үзэж, эрэмбэлэн хэрэгжүүлэх үндсэн зарчимтай бөгөөд дээрх хууль, журам, аргачлалд заасны дагуу холбогдох төрийн байгууллагууд төлөвлөж, түүний дагуу ирсэн саналуудыг хуульд нийцүүлэн боловсруулдаг.

Иймд Монгол Улсын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, бүтээн байгуулалтын төслүүдийн зарцуулалтад “Гишүүний мөнгө” гэх ойлголттой холбоотойгоор ямар нэгэн нөлөөлөл байхгүй бөгөөд Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагад бүрэн нийцсэн болно.

Асуулга 6-ийн хариу:

Төсвийн бодлогын зорилго нь макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн байдаг. Эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, хэт халалтын нөхцөл байдал үүссэн тохиолдолд төсвийн зардлыг хумих буюу төсвийг алдагдалгүй төлөвлөх, харин эдийн засгийн өсөлт саарах, потенциал түвшнээс доогуур ороход идэвхжилийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн төсвийн тэлэх бодлого буюу төсвийг алдагдалтай төлөвлөдөг олон улсын жишиг байдаг.

Дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал 2026 онд үргэлжлэх төлөвтэй байгаагаас манай улсын эдийн засгийн өсөлт саарах, бүтээмж өндөртэй салбаруудад хөдөлмөр эрхлэлт буурах чиг хандлага ажиглагдсаар байх тул эдийн засгийн өсөлтөө дунд хугацаанд тогтвортой авч үргэлжлүүлэхэд сангийн бодлого макро эдийн засгийг тогтворжуулах буюу мөчлөг сөрөхөд чиглэж байна.

Түүнчлэн, Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээг 31,600.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 32,980.0 тэрбум төгрөг буюу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тусгасан бөгөөд төсвийн зардал талдаа хүн ам, статистик тооны өсөлтөөр нэмэгдэх зардал, төрийн албан хаагчдын цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн зардал болон томоохон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт буюу зайлшгүй нэмэгдэх зардлын орон зайг бий болгосон.


Асуулга 7-ийн хариу:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 2026 онд Засгийн газрын өрийн дээд хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүний 50 хувь буюу 51.2 их наяд төгрөг байхаар, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний 43.8 хувь буюу 44.9 их наяд төгрөг байхаар тус тус тооцож, тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслөөс “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”, “Үндэсний хиймэл дагуул төсөл”-үүдийг Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэхээр зээлийн гэрээг байгуулсан.

Харин “Үндэсний хиймэл дагуул төсөл”-ийн санхүүжилтийн гэрээ байгуулагдаагүй буюу санал солилцох, хэлэлцээрийн шатанд байгаа тул Засгийн газрын өрийн 2026 оны төсөөлөл болон дунд, урт хугацаанд нөлөөлөл үзүүлэхгүй байх төлөвтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 278 ДУГААР ТОГТООЛ: “ТӨСВИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ,
САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ”





МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.23 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан аргачлалыг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах, аргачлалын гарын авлага, маягтыг боловсруулах болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хөгжүүлэлтийг хийж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар /Ч.Чимидсүрэн/, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.

Б.ЖАВХЛАН

9763000528

Сангийн сайдын 2023 оны 7
дугаар сарын 7-ны өдрийн тоот 137
тушаалын хавсралт

УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОНОВЧТОЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Нэг.Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү аргачлалын зорилго нь улсын хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслүүдийг нэгдсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг урьдчилсан үнэлгээг хийж төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, тусламж зэрэг санхүүжилтийн эх үүсвэрийг эрэмбэлэн тогтооход оршино.
- 1.2 Энэхүү аргачлалыг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем (цаашид “Цахим систем” гэх)-д суурилан хэрэгжүүлнэ.
- 1.3 Цахим системийн “Төслүүдийн урьдчилсан үнэлгээ хийх” цэсийг сонгож ажиллах ба урьдчилсан үнэлгээнд шаардагдах мэдээллийг оруулж, үнэлгээг хийх бөгөөд холбогдох гарын авлагыг баримтлан ажиллана.

Хоёр.Төслийг урьдчилан үнэлэх үе шат

2.1 Шинэ төслийн саналыг гаргах, урьдчилан үнэлэх үйл ажиллагааг дараах үе шат, цаглавраар хэрэгжүүлнэ. Үүнд:

Үе шат	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлэх процесс	Хугацаа
1-р үе шат: Төслийн санал гаргах	Аймаг, нийслэлийн засаг дарга	Төслийг санаачлагч энэхүү аргачлалд заасан асуулгын дагуу төслийн саналыг үнэлэн, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ.	Жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор
2-р үе шат: Төслийг үнэлэх	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсвийн ерөнхийлөн захирагч нар төрийн захиргааны төв байгууллагатай хамтран үнэлгээ өгч, хянан баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлнэ.	Жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор
3-р үе шат: Төслийг үнэлэх	Сангийн яам	Сангийн яам төслүүдийн урьдчилсан үнэлгээг хийж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй уялдуулах ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулна.	Жил бүрийн 02 дүгээр сарын 15-аас 03 дугаар сарын 15-ны дотор

2.2 Аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь “Төслийн санал гаргах” 1-р үе шатанд төслийг Хавсралт 1-т тусгагдсан 3 бүлэгт хамаарах асуулгын дагуу бөглөнө. Үүнд:

2.2.1.Төслийн зорилго, үндэслэл;

2.2.2.Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мэдээлэл;

2.2.3.Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө.

2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн урьдчилсан үнэлгээнд оруулах төслийн саналыг аргачлалын дагуу үнэлэн, жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.4 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн саналыг тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн авах, төслийн саналд хийсэн урьдчилсан үнэлгээнд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран үнэлгээ өгч, хянан баталгаажуулах;

2.5 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн урьдчилсан үнэлгээг жил бүрийн 02 дугаар сарын 01-ээс 04 дүгээр сарын 01-ний дотор хийж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй уялдуулах ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулна.

2.6 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг урьдчилсан үнэлгээний аргачлалын дагуу нэгдсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлно.

2.7 Урьдчилсан үнэлгээний аргачлалын шалгуур үзүүлэлтийн асуулгыг энэхүү аргачлалын 1 дүгээр хавсралт, асуулгын тайлбарыг 2 дугаар хавсралтад дурдсаны дагуу хэрэгжүүлнэ.

Гурав.Төслийг үнэлж, шалгаруулах процесс

3.1 Төсвийн хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээний маягтыг энэ аргачлалын хавсралт №1-д заасан маягтын дагуу цахим мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулж боловсруулна.

3.2 Төслийн саналыг үнэлэхдээ тэнцсэн, тодорхойгүй болон тэнцээгүй гэсэн ерөнхий үзүүлэлтэд хамаарах 3 шалгуур үзүүлэлтийг ашиглаж, дараах байдлаар ангилна. Үүнд:

- 1) Тэнцсэн: Бүх шалгуур үзүүлэлтийн шалгуурыг хангаж, “Тэнцсэн” үнэлгээ авсан
- 2) Тодорхойгүй: “Тэнцээгүй” гэсэн үнэлгээ байхгүй ч зарим “Тодорхойгүй” гэсэн үнэлгээтэй, гэхдээ татгалзах үндэслэл одоогоор байхгүй
- 3) Тэнцээгүй: “Аль нэг асуултыг хариулаагүй”, “Аль нэг асуултын хариултыг “Тэнцээгүй” гэж үнэлсэн”, “Нийт 10 буюу түүнээс дээш тооны асуултыг “Тодорхойгүй” гэж үнэлсэн” гэсэн шалтгаануудын аль нэгийг нь хангаж байвал татгалзах үндэслэл болно.

3.3 Төслийн санал нь “тэнцсэн” гэсэн үнэлгээг шалгуур бүртээ авсан тохиолдолд тус саналыг тэнцсэн гэж үзэн төлөвлөгөөнд тусгах жагсаалтад оруулна.

3.4 Төслийг үнэлж буй мэргэжилтэн төслийн санал нь тодорхойгүй үнэлгээг авсан тохиолдолд тус саналыг нэмж боловсруулахаар буцаана.

3.5 Төслийн санал шалгуур тус бүртээ тэнцээгүй үнэлгээ авсан тохиолдолд тус төслийг цаашид үнэлэхээс татгалзан, буцааж болно.

3.6 Төслийн саналыг үнэлэхдээ Хүснэгт 2-т заасан зааварчилгааны дагуу үнэлнэ.

“Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”-ын 1 дүгээр хавсралт

Хүснэгт 1: Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний асуулга

№	УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА
	Төслийн нэр
	Төсөл хэрэгжих салбар
	Төсөл хэрэгжих байршил /Аймаг/нийслэл, сум/дүүрэг/
	Төслийн санал ирүүлсэн ТЕЗ
	1. Төслийн үндсэн мэдээлэл
1.1	Төслийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлно уу.
1.2	Төслийг хувийн хэвшлийн байгууллагаар эсвэл ТББ-аар шийдвэрлэх боломжтой юу?
1.3	Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлж болох уу?
1.4	Төслийг хэрэгжүүлэхгүй байснаар ямар үр дагаварт хүрэх вэ?
1.5	Төсөл нь хөгжлийн бодлогын зорилтуудтай хэрхэн уялдаж байгаа вэ?
1.6	Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх боломжтой юу?
1.7	Уг төсөлтэй ижил, давхацсан төсөл, үйл ажиллагаа байгаа эсэхийг тодорхойлно уу.
1.8	Төслийн зорилго юу вэ?
1.9	Төслийг хэрэгжүүлэх үе шатуудыг нэрлэнэ үү.
1.10	Төслийг хэрэгжүүлснээр ямар үр дүн хүлээгдэж байна вэ?
1.11	Төслийн эцсийн хэрэглэгчид болон үр шим хүртэгчдийг тодорхойлно уу.
	2. Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мэдээлэл
2.1	Төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай нийт санхүүжилтийн дүнг бичнэ үү.
2.2	Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн дүнг жилээр задлан бичнэ үү.
2.3	Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн төрлийг санал болгоно уу.
2.4	Энэхүү төсөл нь бүрэн ажиллагаатай, үр дүнтэй байхын тулд өөр холбоотой төслүүдэд зардал гаргах шаардлагатай юу?
2.5	Төслийг хэрэгжүүлсний дараах үйл ажиллагааны урсгал зардлын дүн хэд байх вэ?
2.6	Урсгал зардлын эх үүсвэрийг тодорхойлно уу.
2.7	Төсөлтэй холбоотойгоор газрыг чөлөөлөх, шилжүүлэн авах шаардлага гарах уу?
2.8	Уг төсөл нь орлого олох боломжтой бол жилийн орлого хэд байхаар тооцоолж байна вэ?
	3. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
3.1	Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хугацаа (хугацааг сар/ жилээр бичнэ үү)

3.2	Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох шаардлагатай төрийн байгууллагууд болон агентлагуудыг жагсаана уу. Мөн шийдвэрлэх шаардлагатай хууль зүйн зохицуулалтуудыг бичнэ үү.
3.3	Төслийн сөрөг нөлөөллийг тодорхойлж бичнэ үү.
3.4	Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд гарч болзошгүй бэрхшээлүүдийг тодорхойлно уу.

“Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”-ын 2 дугаар хавсралт

Хүснэгт 2: Төслийг урьдчилсан үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн тайлбар

Асуулга		Үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтүүд		
1. Төслийн зорилго, үндэслэл		Тэнцсэн	Тодорхойгүй	Тэнцээгүй
1.1	Төслийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлно уу.	Асуудал, бэрхшээл, түүний шалтгааныг тодорхой хэмжээний нотолгоотойгоор бүрэн тайлбарласан байна.	Асуудлын цар хүрээ, боломжийн талаар тоон мэдээлэл хангалтгүй байна.	Асуудал, боломжийг тайлбарлаагүй эсвэл асуудал, боломжийг тайлбарласан боловч ач холбогдолгүйгээр тайлбарласан.
1.2	Дээрх төслийг хувийн хэвшлийн байгууллагаар эсвэл ТББ-аар шийдвэрлэх боломжтой юу?	Тухайн төслийг төрийн байгууллагаас хэрэгжүүлэх нь хамгийн тохиромжтой гэдэг нь тодорхой байна.	Төслийг төрийн байгууллага, хувийн хэвшил эсвэл ТББ-аас хэрэгжүүлэх хамгийн тохиромжтой эсэх нь тодорхойгүй байна.	Асуултад дэлгэрэнгүй тайлбартайгаар хариулаагүй байна.
1.3	Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлж болох уу?	Өгсөн хариулт нь найдвартай, үнэмшилтэй байна. "Тийм" гэж хариулсан бол холбогдох албан тушаалтнуудтай хэлэлцсэн бөгөөд хураангуйг нь оруулжээ.	Хариултыг өгсөн боловч тайлбар алга.	Өгсөн хариулт нь найдваргүй, үнэмшил төрүүлэхүйц биш байна. "Тийм" гэж хариулсан мөртөө ямар ч үндэслэл, нотолгоо байхгүй байна.
1.4	Төслийг хэрэгжүүлэхгүй байснаар ямар үр дагаварт хүрэх вэ?	Үр дагаврыг тодорхой тайлбарласан бөгөөд ач холбогдолтой болох нь ойлгомжтой байна.	Үр дагаврыг тайлбарласан боловч тодорхойгүй байна.	Үр дагаврыг нь сайн тайлбарлаагүй байна эсвэл ач холбогдолгүй тайлбартай байна.
1.5	Төсөл нь хөгжлийн бодлогын зорилтуудтай	Төрийн болон холбогдох салбарын бодлого, стратегийг дурдан	Төрийн болон салбарын бодлого, стратегийг дурдан тайлбарласан боловч санал	Санал болгож буй төсөл болон төрийн, салбарын бодлого стратегийн хооронд

	хэрхэн уялдаж байгаа вэ?	тэдгээртэй холбон тайлбарласан.	болгож буй төсөлтэй нягт холбоо нь тодорхойгүй.	ямар ч холбоо харагдахгүй байна.
1.6	Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх боломжтой юу?	Хариулт нь тодорхой бөгөөд итгэл төрүүлэхээр байна.	Өгсөн хариулт нь тодорхойгүй эсвэл хоёрдмол утгатай байна. Хэрэв асуултад "Тийм" гэж хариулсан тохиолдолд шаардсан нэмэлт мэдээллийг өгөөгүй байна.	Асуултад зохих хариулт өгөөгүй байна.
1.7	Уг төсөлтэй ижил, давхацсан төсөл, үйл ажиллагаа байгаа эсэхийг тодорхойлно уу.	Дараах хувилбарын аль нэгийг тодорхойлсон үед: Тухайн салбарт урьд өмнө ийм ижил төрлийн төсөл хэрэгжүүлж байгаагүй, гэхдээ эрсдэлийн эсрэг найдвартай арга хэмжээнүүдийг тодорхойлж бичсэн байна. Эсвэл урьд өмнө ийм төсөл хэрэгжсэн бөгөөд үр дүн нь эерэг байсан.	Эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлж оруулаагүй байна.	Тухайн газарт эсвэл салбарт урьд өмнө ийм ижил төрлийн төсөл хэрэгжүүлж байгаагүй, гэхдээ эрсдэлийн эсрэг найдвартай арга хэмжээнүүдийг тодорхойлж бичээгүй байна. Эсвэл тухайн газарт эсвэл салбарт урьд өмнө ийм ижил төрлийн төсөл хэрэгжсэн боловч үр дүн нь хангалтгүй байсан, эрсдэлийг бууруулах арга хэмжээ аваагүй байсан.
1.8	Төслийн зорилго юу вэ?	Зорилгоо тодорхой тайлбарласан байна.	Зорилтуудаа тайлбарласан боловч тодорхой бус, бүрхэг, нарийвчлалгүй байна.	Зорилтуудаа тайлбарлаагүй байна.
1.9	Төслийг хэрэгжүүлэх үе шат юу байх вэ?	Төлөвлөж буй үйл ажиллагаа, үр дүнг нарийвчлан тодорхойлсон бөгөөд тэдгээр нь төслийн зорилготой нягт уялдаж байна.	Үйл ажиллагаа, үр дүнг тайлбарласан боловч тэдгээр нь төслийн зорилготой нягт холбоотой санагдахгүй байна.	Үйл ажиллагаа болон түүний үр дүнг тайлбарлаагүй.
1.10	Төслийг хэрэгжүүлснээр ямар үр дүн хүлээгдэж байна вэ?	Хүлээгдэж буй үр дүнг нарийвчлан тодорхойлсон	Хүлээгдэж буй үр дүнг тайлбарласан боловч тоо хэмжээ, цаг хугацааны	Асуултад бүрэн хариулахыг хичээгээгүй байна.

		бөгөөд төслийн зорилготой холбоотой байна.	талаар хангалттай мэдээлэл байхгүй байна.	
1.1 1	Төслийн эцсийн хэрэглэгчид болон үр шим хүртэгчдийг тодорхойлно уу.	Хүлээгдэж буй үр дүнг нарийвчлан тодорхойлсон бөгөөд тэр нь төслийн зорилготой холбоотой байна.	Хүлээгдэж буй үр дүнг тайлбарласан боловч тоо хэмжээ, цаг хугацааны талаар хангалттай мэдээлэл байхгүй байна.	Асуултад бүрэн хариулахыг хичээгээгүй байна.
2.	Санхүүгийн мэдээлэл	Тэнцсэн	Тодорхойгүй	Тэнцээгүй
2.1	Төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай нийт санхүүжилтийн дүнг бичнэ үү.	Мэдээлэл нь тодорхой бөгөөд өгсөн тооцоо нь ижил төрөл, цар хүрээтэй төслийнхтэй дүйцсэн, бодитой байна.	Мэдээлэл нь найдвартай байж болох боловч нэмэлт тодруулга шаардлагатай	Мэдээлэл нь бүрэн бус эсвэл бодит биш, итгэл төрүүлэхгүй байна.
2.2	Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн дүнг жилээр задлан бичнэ үү.	Хариултаар өгсөн мэдээлэл нь тодорхой бөгөөд тооцоо нь бодитой байна. Нийт тооцоог хялбарчилж хэд хэдэн жилд тэнцүү хуваагаагүй байна.	Хариултаар өгсөн мэдээлэл нь тодорхой бөгөөд тооцоо нь бодитой байна. Нийт тооцоог хялбарчилж хэд хэдэн жилд тэнцүү хуваагаагүй байна.	Мэдээлэл нь бүрэн биш, эсвэл бодит биш, итгэл төрүүлэхгүй байна.
2.3	Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн төрлийг санал болгоно уу.	Хариултаар өгсөн мэдээлэл нь бүрэн, тодорхой байна. Нийт тооцоо нийлбэрээрээ таарч байгаа бөгөөд 1-р хэсэгт заасан тоотой нийцэж байна.	Мэдээлэл бүрэн байж болох боловч илүү тодруулах шаардлагатай.	Мэдээлэл нь бүрэн бус эсвэл бодит биш, итгэл төрүүлэхгүй, эсвэл нийлбэрээрээ таарахгүй байна.
2.4	Энэхүү төсөл нь бүрэн ажиллагаатай, үр дүнтэй байхын тулд өөр холбоотой төслүүдэд зардал гаргах шаардлагатай юу?	"Тийм" эсвэл "үгүй" гэж хариулсныг бүрэн тайлбарласан бөгөөд найдвартай санагдаж байна.	Өгсөн мэдээлэл бүрэн боловч илүү тодруулах шаардлагатай байна.	"Тийм" гэж хариулсан тохиолдолд мэдээлэл өгөөгүй, "үгүй" гэж хариулсан тохиолдолд тайлбар нь найдвартай санагдахгүй байна.
2.5	Төслийг хэрэгжүүлсний дараах үйл ажиллагааны урсгал зардлын дүн хэд байх вэ?	Өгсөн мэдээлэл бүрэн, тодорхой бөгөөд тооцоо нь бодит байна.	Мэдээлэл бүрэн боловч илүү тодруулга шаардлагатай байна.	Мэдээлэл нь бүрэн биш, эсвэл бүрэн боловч бодит бус, эсвэл үнэмшил төрүүлэхгүй байна.

2.6	Урсгал зардлын эх үүсвэрийг тодорхойлно уу.	Мэдээлэл бүрэн, тодорхой бөгөөд эх сурвалжууд бодитой байна.	Мэдээлэл бүрэн өгсөн боловч илүү тодруулах шаардлагатай байна.	Мэдээлэл нь бүрэн биш, эсвэл бүрэн боловч бодит бус, эсвэл үнэмшил төрүүлэхгүй байна.
2.7	Төсөлтэй холбоотойгоор газрыг чөлөөлөх, шилжүүлэн авах шаардлага гарах уу?	Өгсөн мэдээлэл нь бүрэн, тодорхой бөгөөд бодитой байна.	Мэдээлэл өгсөн боловч илүү тодруулах шаардлагатай.	Мэдээлэл өгөөгүй эсвэл өгсөн боловч бодитой биш байна.
2.8	Уг төсөл нь орлого олох боломжтой бол жилийн орлого хэд байхаар тооцоолж байна вэ?	Төсөл нь орлого бүрдүүлэхгүй нь тодорхой, эсвэл бүрдүүлэх ч харуулсан тооцоо нь нотолгоотой, найдвартай байна.	Төсөл нь орлого бүрдүүлэх ч өгсөн тооцоо нь үндэслэлгүй.	Асуултад хариулахыг хичээгээгүй эсвэл төсөл орлоготой байх бөгөөд энэ талаар өгсөн хариулт нь үнэмшил төрүүлэхгүй байна.
3. Хэрэгжүүлэх төлөвлөгөө		Тэнцсэн	Тодорхойгүй	Тэнцээгүй
3.1	Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөт хугацаа (хугацааг сар/ жилээр бичнэ үү)	Төлөвлөгөө нь тодорхой бөгөөд бодитой, хэрэгжихүйц байна.	Танилцуулсан төлөвлөгөө нь бодит юм шиг байгаа боловч илүү тодорхой болгох шаардлагатай.	Хугацаа нь найдвартай биш эсвэл ямар нэгэн тодорхой мэдээлэл өгөөгүй байна.
3.2	Төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцох шаардлагатай төрийн байгууллагууд болон зохицуулах агентлагуудыг жагсаана уу. Мөн шийдвэрлэх шаардлагатай хууль зүйн зохицуулалтуудыг бичнэ үү.	Холбогдох бүх байгууллагуудыг жагсаасан, шийдвэрлэх шаардлагатай эрхзүйн болон зохион байгуулалтын бүх асуудлуудыг тайлбарласан байна.	Холбогдох байгууллагуудын талаарх мэдээлэл оруулсан боловч мэдээлэл дутагдалтай байна	Шаардлагатай мэдээллийг өгөхийг оролдоогүй, эсвэл өгсөн хариулт нь итгэл төрүүлэхгүй байна.
3.3	Төслийн сөрөг нөлөөллийг тодорхойлж бичнэ үү.	Нөлөөллийг цар хүрээгээр нь тодорхой тайлбарласан байна.	Нөлөөллийг жагсаасан боловч цар хүрээг нь тайлбарлаагүй эсвэл тайлбарласан ч үнэмшил төрүүлэхээргүй байна.	Нөлөөллийг тайлбарлаагүй байна (энэ нь ямар нэгэн нөлөөгүй бөгөөд яагаад нөлөөлөл байхгүй тайлбарласан тохиолдолд хамаарахгүй)

3.4	Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд гарч болзошгүй бэрхшээлүүдийг тодорхойлно уу.	Хамгийн их эрсдэлийг асуудлуудыг орхигдуулахгүйгээр жагсаасан байна	Зарим эрсдэлийг дурдсан боловч бусад эрсдэлтэй асуудлыг тайлбарлаагүй байх магадлалтай.	Асуултуудад хариулахыг хичээгээгүй байна.
-----	---	---	---	---



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А1264

Улаанбаатар хот

Журам болон аргачлалд
өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Журам болон аргачлал батлах тухай" Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 5.2 дахь хэсгийг "Шинээр хэрэгжүүлэх төслүүдийг Аргачлал 2, 3-т заасны дагуу Цахим системд үнэлэх болон сонгох үнэлгээг хийж, оноо өгч эрэмбэлэн сум дүүрэг нь 04 дүгээр сарын 30-ны дотор аймаг, нийслэлд, аймаг, нийслэл нь 06 дугаар сарын 25-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчдад, төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн салбарт шинээр хэрэгжүүлэх нийт төслийн жагсаалтыг 07 дугаар сарын 25-ны дотор нэгтгэн цахим системээр болон албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлнэ." гэж, 5.3 дахь хэсгийг "Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн ерөнхийлөн захирагчдаас үнэлэх болон сонгох үнэлгээ хийгдсэн төслийн саналыг хянаж, төсвийн төсөлд тусгах үнэлгээг Цахим системд хийж эрэмбэлэн бэлтгэнэ." гэж, 5.4 дэх хэсгийг "Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй шилжих төслийг Аргачлал 1-д заасны дагуу үнэлгээ хийж, шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг Аргачлал 2-т заасны дагуу сонгож, төсвийн төсөлд тусгуулах нийт төслийн саналаа 07 дугаар сарын 25-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ." гэж, 6.4 дэх хэсгийг "Энэ журамд заасны дагуу үнэлж, эрэмбэлсэн төслийн жагсаалтыг www.publicinvestment.gov.mn, www.iltod.gov.mn, <https://mof.gov.mn> цахим хуудаст болон гар утасны "төсвийн хөрөнгө оруулалт" аппликэйшнээр тухай бүр шинэчлэн оруулж олон нийтэд ил тод мэдээлнэ." гэж тус тус өөрчилсүгэй.

2. "Журам болон аргачлал батлах тухай" Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал"-ын 2.5 дахь хэсгийг "Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү аргачлалын дагуу төслүүдийг ангилж, төсөвт үргэлжлүүлэн тусгах хэвийн төслүүдийн жагсаалт болон эргэлзээтэй ангилалд оруулсан төслийг өөрчлөн хэрэгжүүлэх хувилбарын саналаа 07 дугаар сарын 25-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "Сангийн яам" гэх/-д хүргүүлнэ." гэж өөрчилсүгэй.

3. "Журам болон аргачлал батлах тухай" Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал"-ын 3.4 дэх хэсгийг "Сангийн яамны түвшинд төсөлд үнэлгээ хийх үйл ажиллагааг Аргачлал 2, 3-ын дагуу дараах 2 үе шатаар хэрэгжүүлнэ." гэж өөрчилсүгэй.

9763000953

4. “Журам болон аргачлал батлах тухай” Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 2.1 дэх хэсгийн Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг дараах үе шат, цаглавраар хэрэгжүүлнэ. Үүнд:

Үе шат	Хэрэгжүүлэх процесс	Хугацаа
Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох	Сум дүүрэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналын мэдээллийг цахим системд бүрэн оруулж Аргачлал 2, 3-ын дагуу үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, шалгуур хангасан төслийн санал, жагсаалтыг аймаг, нийслэлд хүргүүлнэ.	Жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны дотор
	Аймаг, нийслэл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналын мэдээллийг цахим системд бүрэн оруулж Аргачлал 2, 3-ын дагуу үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, шалгуур хангасан төслийн санал, жагсаалтыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ.	Жил бүрийн 06 дугаар сарын 25-ны дотор
	Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналын мэдээллийг цахим системд бүрэн оруулж Аргачлал 2, 3-ын дагуу үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, шалгуур хангасан тухайн салбарт хэрэгжүүлэх нийт төслийн санал, жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлнэ.	Жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор
	Сангийн яам ирүүлсэн төслүүдийн үнэлэх, сонгох шалгуур үзүүлэлтийн оноог хянаж, шаардлагатай тохиолдолд оноог засварлан эрэмбэлж төсвийн төсөлд тусгах нэгдсэн жагсаалтыг боловсруулна.	Жил бүрийн 08 дүгээр сарын 25-ны дотор

гэж,

4.1 2.2, 2.3 дахь хэсгийг нэгтгэн “Шинээр хэрэгжүүлэх төслийн үнэлэх, сонгох үнэлгээг хийж, эрэмбэлэхдээ дараах шалгуур үзүүлэлтээр цахим системд эрэмбэлнэ. Үүнд:

2.2.1. бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх;

2.2.2. олон нийтийн санал авсан эсэх;

2.2.3. төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол тооцсон эсэх;

2.2.4. төслийн хүчин чадлын ашиглалтын тооцоолол;

2.2.5. төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх;

2.2.6. төслийн нийт зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;

2.2.7. төсөлтэй холбоотой ашиглалтын хугацааны зардал, түүнийг хэрхэн санхүүжүүлэх;

2.2.8. төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл;

2.2.9. төслийн зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн эсэх;

2.2.10. эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалт эсэх;

4.2. Аргачлалын 2.4 дэх хэсгийн “Төслийг эрэмбэлэх, сонгох 2-р үе шатанд зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, тухайн газар нь чөлөөлөгдсөн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан төслүүдийг оруулж үнэлнэ” гэснийг “Төслийг эрэмбэлэх, сонгох үе шатанд зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, тухайн газар нь чөлөөлөгдсөн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан төслүүдийг оруулж үнэлнэ” гэж;

4.3. Аргачлалын 2.5 дахь хэсгийн “Энэхүү аргачлалын 2.2 болон 2.3-т заасан ангиллын шалгуур үзүүлэлт бүр нь тус тус 5 асуулгатай байх ба төслийг үнэлэхдээ тухайн шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгааг Аргачлалын хавсралт дах Хүснэгт №2 – №3-т заасан тохирох хариултыг сонгосноор оноо өгөгдөнө” гэснийг “Энэхүү аргачлалын 2.2-т заасан ангиллын шалгуур үзүүлэлт бүр нь тус тус 5 асуулгатай байх ба төслийг үнэлэхдээ тухайн шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгааг Аргачлалын хавсралт дах Хүснэгт №2 т заасан тохирох хариултыг сонгосноор оноо өгөгдөнө” гэж;

4.4. Аргачлалын 2.6, 2.7 дахь хэсгийг нэгтгэн “Төслийг үнэлэх, сонгох, эрэмбэлэх шалгуур үзүүлэлт тус бүрийн оноо нь төслийн стратегийн ач холбогдол, эрэлт хэрэгцээ, эдийн засгийн үнэ цэнэ, санхүүгийн үндэслэл, болзошгүй эрсдэл, төслийн бэлэн байдал, бодлогын баримт бичигтэй нийцэж буй байдал, улсын төсөвт нөлөөлөх ачаалал, төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэлийг хянаж удирдах, төсөл хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж буй эсэхийг үнэлнэ” гэж;

4.5. Аргачлалын 3.1 дэх хэсгийн “Төслийг үнэлэх 1-р үе шат болон төслийг сонгох 2-р үе шатанд төслийг үнэлж, оноо өгөх процесс нь Цахим системийн үнэлгээний матрицаар хийгдэнэ” гэснийг “Төслийг үнэлэх, сонгох үйл ажиллагаанд төслийг үнэлж, оноо өгөх процесс нь Цахим системийн үнэлгээний матрицаар хийгдэнэ” гэж;

4.6. Аргачлалын 3.2 дэх хэсгийн “Цахим системд Аргачлалын 2.2 болон 2.3-т заасан ангилал болон шалгуур үзүүлэлтүүд, түүнд хамаарах оноо өгөх асуулга, ач холбогдлыг нь харгалзан 1 – 3 дахин нэмэгдүүлэх тогтмол жинг Сангийн яамнаас оруулсан байна” гэснийг “Цахим системд Аргачлалын 2.2-т заасан ангилал болон шалгуур үзүүлэлтүүд, түүнд хамаарах оноо өгөх асуулга, ач холбогдлыг нь харгалзан 1 – 3 дахин нэмэгдүүлэх тогтмол жинг Сангийн яамнаас оруулсан байна” гэж;

4.7. Аргачлалын 4.2 дахь “Төслийг үнэлэх 1-р үе шатанд өгөгдсөн нийт оноо болон төслийг эрэмбэлэх, сонгох 2-р үе шатанд өгөгдсөн нийт онооны нийлбэрээр тухайн төслийн эцсийн оноо тодорхойлогдоно” гэснийг “Төслийг үнэлэх, сонгох үйл ажиллагаанд өгөгдсөн нийт онооны нийлбэрээр тухайн төслийн эцсийн оноо тодорхойлогдоно” гэж;

4.8. Аргачлалын хавсралтын Хүснэгт 1-г дор дурдсанаар:

Хүснэгт 1: Төслийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх, сонгох оноо өгөх ерөнхий загвар

Үе шат	Шалгуур үзүүлэлт	Төсвийн ерөнхийлөн захирагч			Сангийн яам		
		Оноо	Жин	Дүн	Оноо	Жин	Дүн
Төслийг үнэлэх, сонгох эрэмбэлэх	I Бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх	5	1.5	7.5	5	1.5	7.5
	II Олон нийтийн санал авсан эсэх	5	2	10.0	5	2.0	10.0
	III Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	IV Төслийн хүчин чадлын ашиглалт	5	1.5	7.5	5	1.5	7.5
	V Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх	5	2	10	5	2	10
	VI Төслийн нийт зардлыг бүрэн тооцсон эсэх	5	3	15	5	3	15
	VII Төсөлтэй холбоотой ашиглалтын хугацааны зардал, түүнийг санхүүжүүлэх санал	5	1	5	5	1	5
	VIII Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл	5	1	5	5	1	5
	IX Төслийн зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн эсэх;	5	2.5	12.5	5	2.5	12.5
	X Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалт эсэх;	5	2.5	12.5	5	2.5	12.5
Дүн:		100.0			100.0		

1.1.9. Аргачлалын хавсралтын Хүснэгт 2-г дор дурдсанаар:


Шалгуур үзүүлэлт	Асуулга	Харгалзах оноо
I Бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх	• Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдсан;	1 оноо
	• Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан;	2 оноо
	• Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан;	3 оноо
	• Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэртэй;	4 оноо
	• Тухайн жилийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан;	5 оноо
II Олон нийтийн	• Олон нийтийн саналыг аваагүй	1 оноо

Шалгуур үзүүлэлт		Асуулга	Харгалзах оноо
	санал авсан эсэх	• Олон нийтэд танилцуулсан	2 оноо
		• Тухайн төслөөс бий болох үйлчилгээг хүртэх иргэдээс санал авсан	3 оноо
		• Төлөвлөж буй төслийн зураг төсөв, хийц, загвар зэрэгт иргэдийн саналыг авсан.	4 оноо
		• Олон нийтэд танилцуулж, санал авч, эрэмбэлсэн	5 оноо
III	Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол	• Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол тодорхой бус;	1 оноо
		• Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол хязгаарлагдмал;	2 оноо
		• Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол дунд зэрэг;	3 оноо
		• Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол өндөр;	4 оноо
		• Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол маш өндөр;	5 оноо
IV	Төслийн хүчин чадлын ашиглалт	• 5 дах жилээс хойш;	1 оноо
		• 4 дэх жилдээ;	2 оноо
		• 3 дах жилдээ;	3 оноо
		• 2 дах жилдээ;	4 оноо
		• Эхний жилдээ;	5 оноо
V	Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх	• Мэргэжилтэй боловсон хүчин тусгайлан бэлтгэнэ;	1 оноо
		• Гадаадаас мэргэжилтэн урьж ажиллуулна;	2 оноо
		• Ажлын байранд дадлагажуулна;	3 оноо
		• Мэргэжлийн ажиллагсад зах зээлд олдоцтой;	4 оноо
		• Ижил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан мэргэжилтэй боловсон хүчин бэлэн.	5 оноо
VI	Төслийн зардлыг бүрэн, зөв тооцсон эсэх	• Нэг маягийн зураг төсөв, жишиг үнэлгээгээр тооцоолсон;	1 оноо
		• Төслийн зардалд тодорхой ажлууд дутуу тооцогдсон;	2 оноо
		• Төслийн зардал өнөөгийн бодит зах зээлийн үнээс 20-оос дээш хувиар зөрүүтэй;	3 оноо
		• Төслийн зардал өнөөгийн бодит зах зээлийн үнээс 20 хүртэл хувиар зөрүүтэй;	4 оноо
		• Төслийн зардал өнөөгийн үнээр бүрэн тооцогдсон;	5 оноо
VII	Төсөлтэй холбоотой	• Урсгал зардлыг төсвөөс санхүүжүүлэхээр дунд хугацааны зардалд тусгагдаагүй.	1 оноо

Шалгуур үзүүлэлт		Асуулга	Харгалзах оноо
VIII	Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл	• Урсгал зардлыг төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн зарлагын хязгаарт тусгасан;	2 оноо
		• Урсгал зардлын 60 хүртэлх хувийг төсвөөс санхүүжүүлэхээр дунд хугацааны урсгал зардлын хязгаарт тусгасан;	3 оноо
		• Урсгал зардлын 30 хүртэлх хувийг төсвөөс санхүүжүүлэхээр урсгал зардлын дунд хугацааны хязгаарт тусгасан;	4 оноо
		• Урсгал зардлыг өөрийн орлогоор тогтвортой санхүүжүүлэх боломжтой;	5 оноо
		• Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй;	1 оноо
		• Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл өндөр;	2 оноо
		• Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл дунд зэрэг;	3 оноо
		• Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл бага;	4 оноо
		• Эрсдэлийн хүчин зүйлийг хянаж зохицуулах боломжтой;	5 оноо
		• Жишиг, ижил төстэй зураг төсөв	1 оноо
IX	Магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй эсэх	• Нэг маягийн зураг төсөв	2 оноо
		• Сүүлийн 2 жилээс өмнө хийгдсэн бие даасан зураг төсөвтэй	3 оноо
		• Холболтын бие даасан, сүүлийн 2 жилд хийгдсэн зураг төсөвтэй	4 оноо
		• Сүүлийн 2 жилд батлагдсан бие даасан зураг төсөвтэй	5 оноо
		• Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалтын үзүүлэлт байхгүй	1 оноо
X	Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалт эсэх;	• Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалтын үзүүлэлт 20%	2 оноо
		• Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалтын үзүүлэлт 50%	3 оноо
		• Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалтын үзүүлэлт 80%	4 оноо
		• Эрчим хүчний хэмнэлттэй эсвэл ногоон хөрөнгө оруулалтын үзүүлэлтийг бүрэн хангах норм, стандартаар төлөвлөсөн	5 оноо

гэж тус тус өөрчлөх.

1.2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга /Ч.Чимидсүрэн/, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.07.04 № 01/6731

танай _____ -ны № _____ -т

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийг хавсралтаар хүргүүлж байна.

Төсвийн удирдамж, түүний хавсралт маягтуудыг Сангийн яамны <https://mof.gov.mn/article/budget/Budget-police> цахим хуудаснаас татан авч төсвийн төсөл бэлтгэхэд ашиглана уу.

Хавсралт №1. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж;

Хавсралт №2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаар.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001369



САНГИЙН ЯАМ

Төсөл
Хавсралт №1

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ

(Улсын төсөв, Нийгмийн
даатгалын сангийн төсөв,
Эрүүл мэндийн даатгалын
сангийн төсөв, Үндэсний
баялгийн сангийн төсөв)

[Төсвийн тухай хуулиас:
8.3.4.санхүү, төсвийн
асуудал эрхэлсэн төрийн
захиргааны төв
байгууллага Засгийн
газрын баталсан жилийн
төсвийн хязгаарыг
төсвийн удирдамжийн
хамт жил бүрийн 7 дугаар
сарын 5-ны дотор
төсвийн ерөнхийлөн
захирагчид хүргүүлэх]

[Төсвийн удирдамж болон
төсөв бэлтгэх маягтууд,
судалгааны хүснэгтүүд MS
Word болон MS Excel файл
хэлбэрээр Сангийн яамны
веб хуудсанд тавигдсан
болно]

[Холбоос линк](#)

Улаанбаатар хот
2025.06.26

АГУУЛГА

1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР.....	3
2. ТЕЗ НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР.....	3
2.1 Төсвийн хязгаарт багтсан санал бэлтгэх	3
2.2 Төсвийн орлогын санал боловсруулах:	3
2.3 Төсвийн урсгал зардлын санал боловсруулах.....	4
2.4 Төсвийн маягт бөглөх заавар:.....	6
2.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал боловсруулах:.....	7
2.6 Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх	9
2.7 Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах	11
2.8 Төсвийн ангилал.....	11
2.9 Төсвийн санал хүлээн авч хянах.....	12
3. ТӨСВИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	12
4. ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР	13
4.1 Төсвийн үндсэн маягт буюу ТМ-01	13
4.2 Төсвийн үндсэн маягтын нэмэлт буюу ТМ-01а.....	16
4.3 Төсвийн удирдамжид дагалдсан төсвийн маягтуудын товчоо.....	16
4.4 Бусад.....	17

1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР

Улсын Их Хурлаас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг ДНБ-ий 31.7 хувь, нийт зарлагыг ДНБ-ий 31.7 хувь байхаар тус тус тогтоосонтой нийцүүлж "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаар"-ыг боловсрууллаа. *(Улсын төсөв, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн хязгаарын төслийг Сангийн сайдын албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү)*

2. ТЕЗ НАРЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР

2.1 Төсвийн хязгаарт багтсан санал бэлтгэх

2.2.1 2025 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвийн суурь зарлага ба нийт зарлагын хязгаарыг тогтоож байгаатай холбогдуулан зөвхөн зарлагын хязгаарт багтсан төсвийн санал хүлээн авна. Төсвийн хязгаараас хэтэрсэн саналыг Сангийн яам хянахгүй болохыг онцгой анхаарах.

2.2.2 Төсвийн төсөл хүлээн авах Fiscal программ дээр дээрх хөгжүүлэлтийг тусгасан бөгөөд систем дээр тэтгэвэрт гарах тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, бусад зардлын нийт дүн хязгаар давсан тохиолдолд систем хадгалахгүй болохыг анхаарах.

2.2 Төсвийн орлогын санал боловсруулах:

Төсвийн орлогын төслийг боловсруулахад Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2 дахь хэсэгт заасан шаардлагын дагуу төсвийн зарчмыг мөрдлөг болгож, эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэн боловсруулсан 2026 оны төсвийн орлогын санал, 2021-2024 оны гүйцэтгэл, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийн мэдээллийг баталгаажуулан хавсралтаар ирүүлнэ. Үүнд:

- 2.2.1 Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг аж ахуйн нэгж тус бүрээр тооцон ирүүлэх;
- 2.2.2 Навигацийн орлогын төлөвлөлтийг олон улсын нөхцөл байдал болон гадаад хүчин зүйлд үндэслэн боловсруулан төсвийн саналаа ирүүлэх;
- 2.2.3 Монгол Улсад зорчих гадаадын иргэдэд виз олгох улсын тэмдэгтийн хураамжийн орлогын саналыг өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн улс орон тус бүрээр тооцоолон ирүүлэх;

- 2.2.4 Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогын төсөөллийн саналыг орлогын ангилал, иргэн, хуулийн этгээд тус бүрээр боловсруулан ирүүлнэ.

2.3 Төсвийн урсгал зардлын санал боловсруулах

Төрийн албан хаагчдын орон тооны талаар

- 2.3.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд хамаарах төсвийн байгууллагуудын цалин хөлсний зардлыг тооцохдоо Засгийн газраас баталсан төрийн захиргаа, төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэл, түүнд харгалзах албан тушаалын жагсаалтаар ажилчдын тоог гаргаж, Засгийн газраас баталсан тухайн албан тушаалын цалингийн хэмжээгээр бүтэн жилээр тооцох;
- 2.3.2 “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг 2025 оны тодотголын хүрээнд эхлүүлэхээр тооцож төсвийн төсөлд тусган УИХ-д өргөн мэдүүлээд байна. Тус арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа тул дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:
- а/ чиг үүргийн давхардалтай эсхүл нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсөвт байгууллагуудыг нэгтгэх;
- б/ төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг нийтлэг ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх;
- в/ 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн мөн сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх.

Төсвийн хэмнэлтийн талаар

- 2.3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан мөн 2025 оны төсвийн тодотголын төсөлд туссан дараах

арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул дараах зардлыг төсөвт тусгахгүй. Үүнд:

а/ төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, худалдан авахтай холбоотой зардал;

б/ төсвийн хөрөнгөөр компьютер, хэвлэгч, хувилагч, тавилга, техник хэрэгсэл, автомашин шинээр худалдан авах зардал;

в/ төрийн өндөр албан тушаалтны албан ёсны гадаад томилолт, Засгийн газраас зөвшөөрсөн тохиолдолд Засгийн газрын гишүүдийн гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал;

г/ үндэсний аюулгүй байдал, онцгой байдал, цагдаа, шүүхийн шинжилгээ, хил хамгаалах, хилийн шалган нэвтрүүлэх, батлан хамгаалах салбарын анги, нэгтгэлүүд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эрүүл мэнд, боловсролын салбараас бусад салбар төсвийн хөрөнгөөр сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулахгүй байх, түүнтэй холбоотой зардал;

д/ төсвийн хөрөнгөөр нийтээр тэмдэглэх баяр ёслол, салбарын өдөр, нэрэмжит болон тэмдэглэлт ой, аялал зугаалга, тойрон аялал, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах зардал.

Бусад арга хэмжээний талаар

2.3.4 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилал дээрх цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал зэрэг бусад эдийн засгийн ангилалд тусгах боломжтой зардлыг холбогдох эдийн засгийн ангилалд тусгах. Дээрх эдийн засгийн ангилалд тусгах зардлын задаргааг Хавсралт 11а, 11б-д тусгах. Хэрэв өөр эдийн засгийн ангилалд тусгах боломжтой зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилалд төлөвлөн ирүүлсэн тохиолдолд төсөвт тусгахгүй.

2.3.5 Кибер аюулгүй байдлыг хангах зориулалтыг 80801 үндсэн үйл ажиллагааны мэдээлэл технологийн зардлаас 803170 Кибер аюулгүй байдлыг хангах зориулалтын ангилалд салган төлөвлөнө. Уг зардалд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх төлбөр, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн стандарт нэвтрүүлэх төлбөр, мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлага, хамгаалалтын тоног төхөөрөмж, лицензийн төлбөр, хамгаалалтын программ хангамжийн лицензийн төлбөртэй холбоотой зардлууд багтана.

2.3.6 ЭМДС-ийн зарлагыг 2025 онд 2,293.9 тэрбум төгрөг байхаар батлуулсан. Үүн дотор эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний өмнөх жилүүдийн он дамнасан өр төлбөр болох 315.2 тэрбум төгрөгийг тусгаж, энэ оны эхний 1 дүгээр улиралд төсвийг нь тавьж барагдуулсан. Иймд 2026 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хуульд заасан зарчмыг баримталж, үр дүнд чиглэсэн, үр ашигтай байх, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарсан “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон даатгалын бодлогын шинэчлэлийн арга хэмжээ” төлөвлөж, шаардлагатай тооцооллын хамт ирүүлнэ.

2.3.7 Дээрх чиглэл, төсвийн зарчимтай уялдуулан Эрүүл мэндийн сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг оновчтой болгоход дараах агуулгаар үр дүн, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тодорхойлж ирүүлнэ үү. Үүнд:

- эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг харуулсан үндсэн үзүүлэлт болох хүн амын дундаж наслалт, хүйс тус бүрээр тооцох;
- Хэрэгжүүлэх шинэчлэлийн арга хэмжээ бүрээр үр дүн, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тооцох;
- Эмнэлгүүдийг өр төлбөр, авлагагүй байх талаар тодорхой зорилт тусгах;
- Эмнэлэгт үзүүлэх хүлээлгийн хугацааг бууруулахад чиглэсэн зорилтыг өвчний ангилал тус бүрээр тогтоох;
- Одоо тусгагдаж байгаа эрүүл мэндийн бодлого, удирдлага хөтөлбөрийн өвчтөн даатгуулагчийн эмнэлэгт үзүүлсэн талаарх сэтгэл ханамжийн талаарх зорилт, арга хэмжээг оновчтой болгох, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой санал ирүүлэх;
- Монголд эмчлэгддэг боловч гадаадын бусад орон руу эмчлүүлэхээр явах урсгалыг бууруулахад чиглэсэн өвчний ангилал, тохиолдлыг бууруулахад чиглэсэн зорилт тусгах;
- Монголд эмчлэгддэггүй, гадаадын бусад орон руу эмчлүүлэхээр явах урсгалыг бууруулах зорилгоор шинэ технологи нутагшуулах чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд Монголд эмчилсэн өвчний ангилал, тохиолдлын талаар зорилт тусгах.

2.4 Төсвийн маягт бөглөх заавар:

2.4.1 Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг 1.1_Төсвийн саналын маягт-ын дагуу бэлтгэх (Бүх ТЭЗ нар нарийвчилсан зааварчилгааг энэхүү удирдамжийн 4.1 дахь хэсгээс харах);

- 2.4.2 Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо **1.2_TM-01a маягт бөглөх заавар** дагуу бэлтгэн ирүүлэх;
- 2.4.3 ТЭЗ нар өөрсдийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнг тодорхойлж, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг **1.1_Төсвийн саналын маягт** файл дахь **“TM-01a”** маягт ашиглан тодорхойлох. Маягт бөглөх зааврыг удирдамжийн хавсралт **1.2_TM-01a маягт бөглөх заавар** файлаас үзэх.

2.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал боловсруулах:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2025 оны 7 дугаар сарын 25-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчийн албан тоотоор болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр хүлээн авна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчид хөрөнгө оруулалтын төслийн саналаа бэлтгэхдээ цахим системд заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд энэ удирдамжид заасан шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

- 2.5.1 Төсвийн тухай хуулийн 6, 27, 28, 29, 29¹ болон 31 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8, 11 дүгээр зүйл, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам, 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар “Журам болон аргачлалд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны А/264 дүгээр тушаалын дагуу төлөвлөж, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn болон албан бичгээр ирүүлэх;
- 2.5.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу улсын богино,

- дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, тэдгээрийн зорилтыг хангахад чиглэсэн байх;
- 2.5.3 Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалын дагуу, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр дараах байдлаар төслүүдийг төлөвлөнө:
- 2.5.3.1 төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан шинээр хэрэгжүүлэх төслүүдэд төсвийн төсөлд тусгах үнэлгээг хийх, үр ашгийг тооцсон байх;
- 2.5.3.2 он дамжин хэрэгжих төслүүдэд дахин үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх;
- 2.5.3.3 салбарын бодлого, баримтлах зарчим болон төслүүдийн танилцуулга, мэдээлэл, судалгааг ирүүлэх;
- 2.5.3.4 тухайн салбар 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар ямар үр дүнд хүрэх талаарх үр дүн, үр ашгийг мэдээллийг ирүүлэх;
- 2.5.4 Төсвийн тухай хуулийн 14.2 дахь заалтын дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг **жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн** эх үүсвэртэй уялдуулан боловсруулах;
- 2.5.5 Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2} дахь хэсэгт заасны дагуу газрын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, урсгал зардал болон төслийг бүрэн ашиглалтад оруулахад шаардагдах тоног төхөөрөмжийн өртгийг бүрэн тооцож төсөл, арга хэмжээг төлөвлөх;
- 2.5.6 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтын дагуу шинээр эхлэх төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс 2026 онд санхүүжих дүн нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байх буюу 3 жилд багтаан санхүүжүүлж, дуусгахаар төлөвлөх;
- 2.5.7 Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөх;
- 2.5.8 Барилгын тухай хуулийн 15.2, 13.2 дахь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтын дагуу 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан зураг төсөвтэй, газрын зөвшөөрөл гарсан байх, холбогдох материалыг цахим системд оруулсан байх;
- 2.5.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн улсын төсвийн урсгал зардалд үзүүлэх нөлөөллийн тооцоо, төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны судалгаа, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын мэдээллийг Сангийн

сайдын 295, А/264 дүгээр тушаалын дагуу хийж, цахим системд оруулсан байх;

- 2.5.10 Төсвийн тухай хуулийн 31.4 дэх заалтын дагуу нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй гэж тооцоолсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсвэл санхүүжилтийг бууруулах санал, тооцоог ирүүлэх;
- 2.5.11 Хөгжлийн бодлого, тэр дундаа Монгол Улсын хөгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг хангахад чиглүүлж, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх;
- 2.5.12 Төсөл, арга хэмжээний нэр томьёо, байршил, хүчин чадал, хэмжих нэгж жигд, мөнгөн илэрхийллийг сая төгрөгөөр цахим системд оруулсан байх;
- 2.5.13 Төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгах нийт төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ээс боловсруулж, цахим систем дэх маягтын дагуу нэгтгэн ирүүлсэн байх;
- 2.5.14 Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 дэх хэсэгт заасныг зөрчихгүй байхад анхаарч төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтыг саналаа үндэслэл, тооцоололтой боловсруулж ирүүлсэн байх.
- 2.5.15 Барилга байгууламжийн ашиглалтын зардлыг бууруулах, чанартай, хэрэглээнд нийцсэн бүтээн байгуулалтууд хэрэгжүүлэхийн тулд ногоон технологи, эрчим хүчний хэмнэлттэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангах төслүүдийг түлхүү төлөвлөх, ингэхийн тулд зураг төсвийн ажлын даалгавар боловсруулах, зураг төсвийг хүлээж авах, баталгаажуулахад онцгойлон анхаарах;
- 2.5.16 Төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслүүдийг ашиглалтад оруулахад дийлэнх төслүүдэд нэмэлт санхүүжилт буюу төсөвт өртгийн нэмэгдлийн асуудал үүсэж, төсөвт эрсдэл учирч байгаа тул цаашид шинэ төслүүдийн зураг төсвийн иж бүрдэлд онцгойлон анхаарч, хяналт тавих, тухайн зураг төсвөөр бүрэн ашиглалтад орох боломжийг нягталсны үндсэн дээр төсөвт төлөвлөх;
- 2.5.17 Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын 1.3-т заасны дагуу нэмэлт санхүүжилт үүссэн төслийн саналыг аудитын байгууллагын дүгнэлтийн хамт ирүүлэх;

2.6 Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2026 оны гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн саналаа боловсруулахдаа Засгийн газраас баталсан зарлагын хязгаар болон дунд хугацааны гадаад зээл, тусламжийн бодлого, чиглэлийг удирдлага болгон 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төсвийн

ерөнхийлөн захирагчийн албан бичгээр ирүүлэх бөгөөд төсөл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.6.1 Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээ нь Монгол улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх ба салбарын хөгжлийн бодлого, чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа талаар, төслийн хүлээгдэж буй үр дүнгийн танилцуулгыг MS Word болон MS Power Point хэлбэрээр ирүүлэх;
- 2.6.2 Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслийн саналыг **НМ-09, НМ-09-01** маягтуудад заасны дагуу бэлтгэх ба дараах мэдээллийг тусгана. Үүнд:
 - 2.6.2.1 гадаадын зээл, тусламжаар 2026 онд хэрэгжих төслүүдийг төслийн эх үүсвэр тус бүрээр шилжих, дуусах болон шинэ төслийн ангиллаар гарган, танилцуулгын хамт ирүүлэх;
 - 2.6.2.2 гадаад зээл, тусламжаар 2026 онд хэрэгжих төслүүдийн гэрээ тус бүрээр холбогдох мэдээллийг гарган маягтын дагуу ирүүлэх (**НМ-09-01** маягтыг бөглөх);
 - 2.6.2.3 төслийн санхүүжилтийг урсгал, хөрөнгийн болон эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд хуваарилан тусгах бөгөөд эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын дагуу төсвийн төслийг бэлтгэх;
 - 2.6.2.4 Дамжуулан зээлийн гэрээтэй болон гэрээ хийгдэх төслийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд тусган ирүүлэх ба холбогдох гэрээний хуулбарыг ирүүлэх;
 - 2.6.2.5 санхүүжилтийн эх үүсвэр хэсэгт гадаадын зээл, тусламж, орон нутгийн төсөв болон улсын төсвийн урсгал эсвэл хөрөнгийн эх үүсвэр зэрэг аль эх үүсвэрээр санхүүжихийг тодорхой ирүүлэх;
 - 2.6.2.6 тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлын саналыг тусад нь тооцож ирүүлэх (**НМ-09** маягтын 3-5, 7-9, 15-17 баганыг бөглөх);
- 2.6.3 Төслийн саналыг гэрээний үндсэн валют болон төгрөг гэсэн 2 дүнгээр боловсруулах ба үндсэн валютыг төгрөгт хөрвүүлэхдээ Монгол банкны 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хаалтын ханшаар тооцох;
- 2.6.4 Монголын тал хариуцахаар зээл, тусламжийн гэрээнд туссан хөрөнгийн болон урсгал зардлын саналыг 2.6.1-2.6.3-т зааснаар дэлгэрэнгүй гаргах бөгөөд хөгжлийн түнштэй байгуулсан зээл, тусламжийн гэрээнд монгол тал хариуцахаар туссан гэрээний холбогдох заалт, мэдээллийг зайлшгүй хавсаргаж ирүүлэх (**НМ-09** маягтын 4, 5, 8-12, 15-17 баганыг бөглөх);
- 2.6.5 Мөн гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн Монголын тал хариуцах 2026 оны хөрөнгө оруулалтын ажлын хувьд зураг төсөв,

магадлалаар батлагдсан эсэх мэдээлэл ирүүлэх бөгөөд шилжин хэрэгжиж буй төслийн хувьд төсөвт өртөг, урьд онуудад авсан санхүүжилтийн мэдээллийг өссөн дүнгээр тусган ирүүлэх (НМ-09 маягтын 10-12 баганыг бөглөх);

2.6.6 Мөн гадаадын зээл, тусламжаар 2025 онд хэрэгжиж байгаа төслүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг НМ-9 маягтаар ирүүлнэ. Энэ хүрээнд урсгал, хөрөнгө болон эргэн төлөгдөх зардлыг нийт дүнгээр гаргаж, төслийн үндсэн үйл ажиллагааны данс болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн данс тус бүрээр хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцсон байна (НМ-09 маягтын 2-9 баганыг бөглөх);

2.6.7 Түүнчлэн төслийн хэрэгжилтийн явцын танилцуулга, 2025 оны хэрэгжилтэд учирсан асуудал, төслийн хүрсэн үр дүнгийн танилцуулгыг ирүүлнэ.

2.7 Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах

Төсвийн төлөвлөлтийн үйл явцыг Fiscal программаар дамжуулан авах ба 2026 оны төсвийн зарлагын саналыг онлайнд суурилсан FISCAL-B хувилбарыг ашиглаж Сангийн яаманд ирүүлнэ. Системд өгөгдөл оруулах зааварчилгааг энэхүү удирдамжид хавсаргасан 3_Fiscal-B гарын авлага файлаас харна уу. Программд өгөгдөл оруулахтай холбоотой тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын зөвлөх Ш.Оюунбаатар oyunbaatar@mof.gov.mn хаягаар болон 51-265753 утсаар лавлана уу.

2.8 Төсвийн ангилал

Төсвийн төслийг эдийн засгийн, хөтөлбөрийн болон зориулалт, арга хэмжээний ангиллыг 2015 оны Сангийн Сайдын 7-р тушаалаар батлагдсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”-ын дагуу боловсруулах бөгөөд төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг 2021 оны Сангийн сайдын 190-р тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар батлах тухай”-ыг баримтлан төлөвлөж ирүүлэх;

Төсвийн зардлыг төлөвлөхдөө Төсвийн захирагч бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тохирох хөтөлбөр, түүний хүрэх үр дүн болон үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт төлөвлөн ирүүлнэ. Аливаа арга хэмжээний аль нэг эдийн засгийн ангилалд бөөн дүнгээр зардал төлөвлөхгүй байх, урьд нь бөөн дүнгээр төлөвлөсөн зардлыг зохих хөтөлбөр, арга хэмжээ-зориулалт, эдийн засгийн ангиллаар нь задалж төсөвт тусгах. Ингэснээр салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд бодлогын дүн шинжилгээ хийх, бодит мэдээллийг бүртгэх, төлөвлөлт-гүйцэтгэлийн уялдаа хангагдана;

Хөтөлбөрийн болон арга хэмжээний ангиллын “Ангилалдаагүй бусад” гэсэн хэсгийг сонгож төсвийн санал оруулахгүй байх. Хэрэв уг ангилалд санал оруулсан бол төсвийн төсөлд хянаж, тусгахгүй бөгөөд төсвийн орлого, эх

үүсвэрийн дутагдлаас шалтгаалж төлөвлөсөн зарлагын санхүүжилтийг хойшлуулах, зардлыг бууруулах, эсвэл төсөвт тодотгол хийж бууруулах тохиолдолд энэхүү ангилал нь ач холбогдлоороо хамгийн сүүлд эрэмбэлэгдэхийг анхаарах;

Хөтөлбөрийн орон тооны мэдээллийг ТМ-01 маягтын "Г" хэсэгт заасан ангиллаар төсвийн төлөвлөлтийн FISCAL программд оруулсны дагуу бэлтгэх;

ТМ-01 үндсэн маягт болон нэмэлт маягт (НМ-01-10)-ууд нь зөвхөн ТЭЗ-ийн түвшинд хийгдэх боловсруулалтыг шаарддаг тул төсвийн удирдамж түүний маягтуудыг доод шатны төсвийн захирагчдад шууд хуулбарлан хүргүүлэхгүй байхыг анхаарна уу. Харин эдгээр маягтуудаар төсвийн санал бэлтгэхийн тулд шаардагдах мэдээллийг доод шатны төсвийн захирагчдаас авах (орон тооны судалгаа, тэтгэвэрт гарах хүмүүсийн судалгаа, байгууллагын төсвийн санал гэх мэт) нь зүйтэй.

2.9 Төсвийн санал хүлээн авч хянах

Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсөв болон орон нутгийн төсөвт хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг дор дурдсан хугацаанд хянаж Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэнэ.

Хүснэгт 3. Төсвийн төсөл бэлтгэх процесс

Хяналт болон төлөвлөлтийн процесс	Эхлэх болон дуусах хугацаа
Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсвийн саналыг хүлээн авч хянах	VII/25- VII/31
Жилийн төсвийн төсөлд инфляцын болон бусад бодлогын тохируулга хийх	VIII/01- VIII/10
Төсвийн саналыг олон нийтээр хэлэлцүүлэх	VIII/05- VIII/08
Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төслийг тус тус холбогдох бусад материалын хамт Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэх	VIII/11- VIII/15
ТЭЗ нартай 2026 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг хийж холбогдох тохируулгыг хийн, УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэх	VIII/15- VIII/30

Төсвийн Ерөнхийлөн захирагчид төсвийн төслийн саналаа бэлтгэхдээ маягтад заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд дээрх шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

3. ТӨСВИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Төсвийн тухай хуулийн 28^{1.1.1}-т “төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах”, 28^{1.2.2}-т “хэлэлцүүлгийг салбар бүрээр явуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 сарын 06 өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 2025 оны 8-р сарын 15-ны өдрийн дотор олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна. Уг журамтай <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089516809531&showType=1> хаягаар орж танилцана уу.

Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад анхаарах асуудлууд:

- 3.1. Төсвийн тухай хуулийн 28^{1.2.5}-д олон нийтийн хэлэлцүүлэгт зориулж санал авах асуудлаар хялбаршуулсан танилцуулга боловсруулах гэж заасны дагуу ТЭЗ бүр 4_Төсвийн саналын товч танилцуулга-аар төсвийн төслийн танилцуулгыг бэлтгэнэ.
- 3.2. Төсвийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журмын 2.8 дахь заалтын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах зардлыг салбарын батлагдсан төсвөөс санхүүжүүлнэ.
- 3.3. Дараах урьдчилсан хуваариар хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. (Хэлэлцүүлгийн оролцогчид болон хэлэлцүүлэх асуудлаас шалтгаалан хэлэлцүүлгийн товд өөрчлөлт орж болно.)

Хүснэгт 4. Олон нийтийн хэлэлцүүлгийн урьдчилсан хуваарь

Хэлэлцүүлгийн огноо	Салбар	Хариуцах яамд
2025.08.05	Цахим хөгжил инновац; харилцаа холбоо; гадаад харилцаа; аж үйлдвэр; эрдэс баялаг; хот байгуулалт; барилга; орон сууцжуулалт; зам тээвэр; эрчим хүч; бусад.	ЦХИХХЯ, ГХЯ, АҮЭБЯ, ХББОСЯ, ЗТЯ, ЭХЯ, бусад
2025.08.06	Боловсрол; соёл; спорт; аялал жуулчлал; залуучууд; байгаль орчин; уур амьсгалын өөрчлөлт;	БЯ, ССАЖЗЯ, ОНБТСҮХ, БОАЖЯ
2025.08.07	Гэр бүл; хөдөлмөр; нийгмийн хамгаалал; хүнс; хөдөө аж ахуй; хөнгөн үйлдвэр;	ГБХНХЯ, ХХААХҮЯ
2025.08.08	Эрүүл мэнд; хууль зүй; дотоод хэрэг; аюулгүй байдал;	ЭМЯ, ХЗДХЯ, БХЯ

- 3.4. Сангийн яамны цахим сайтуудаар нэгдсэн журмаар төсвийн төслийн саналуудыг байршуулж, хэлэлцүүлэгт танхимаар оролцогчдыг бүртгэлийг цахимаар хийнэ. Иймд 2026 оны төсвийн төсөл болон 2027-2028 оны төсвийн төсөөллийн саналын файлыг tusuv@mof.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

4. ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР

4.1 Төсвийн үндсэн маягт буюу ТМ-01

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж байгаа бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилна. Удирдамжийн хавсралт файл 1.1_Төсвийн саналын маягт-ыг бөглөхдөө дараах зүйлсийг анхаарах. Үүнд:

- 4.1.1 Урсгал болон хөрөнгийн зардлыг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөрөөр тодорхойлсон байх;
- 4.1.2 Хөтөлбөрийн төсвийн саналыг ТМ-01 маягтад заасны дагуу “А” зардлын эдийн засгийн ангиллаар; “Б” зардлын зориулалт-арга хэмжээгээр; “В” санхүүжүүлэх эх үүсвэрээр задалж дунд хугацаагаар буюу 1-ээс 8 дугаар баганаар харуулсан байх;
- 4.1.3 Бүх хэсгүүдийн өөрчлөлтийн харьцуулалтыг 9, 10, 11 дүгээр баганаар харуулсан байх;
- 4.1.4 Төсвийн төслийг тухайн төсвийн жилийн батлагдсан орлого, зарлагын хязгаарт багтаасан байх (ТМ-01 маягтын 5 дугаар багана);
- 4.1.5 Хэрэв урьдчилан төсөөлөх, төлөвлөх боломжгүй, түүнчлэн УИХ болон Засгийн газраас төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар баталснаас хойш үүссэн нөхцөл байдлын улмаас батлагдсан төсвийн хязгаараас давах, зайлшгүй авч үзэх шаардлагатай төсвийн саналтай бол тооцооны төслийг ТМ-01 маягтын 6 дүгээр баганад харуулах;
- 4.1.6 Хөтөлбөрийн хүрээнд ажиллах орон тооны мэдээллийг төрийн албан хаагчийн ангиллын дагуу маягт ТМ-01 ийн “Г” хэсэгт заасны дагуу үнэн зөв гаргаж харуулах;
- 4.1.7 Хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах төсөв захирагчийн (төсвийн байгууллагын) төсвийн мэдээллийг ТМ-01 маягтын “Д” хэсэгт холбогдох баганаар тусгаж харуулсан байх;
- 4.1.8 Хөтөлбөрийн хүрээнд ирэх он болон түүний дараагийн хоёр жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа зорилтуудыг ТМ-01 маягтын “Е” хэсэгт товч тодорхой тусгана.
- 4.1.9 Зардлын тойм – Зардлын дүн шинжилгээ: ТМ-01 маягтын “Ё” хэсгийг бэлтгэхэд дэмжлэг болгох зорилгоор нэмэлт тайлбар оруулж байна. Тухайн ТЭЗ-ийн багцын хувьд дунд хугацаанд салбарын бодлогын гол тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүнг хангахын тулд салбарын бодлого юунд чиглэж байгаа (ө.х. төсвийн хөрөнгийг юунд голлон зарцуулахаар төлөвлөж байгаа) талаар тайлбарлаж бичнэ. Тухайн багцын төсвийн суурь түвшинд өөрчлөлт оруулсан бол тэр талаар мөн бичнэ. Тухайн ТЭЗ-ын төсөв ямар гол хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хуваарилагдаж буй талаар, мөн нийт зардлын хувьд эдийн засгийн зардлын зүйл болон шилжүүлгүүдэд хэрхэн хуваарилагдсан, гол онцлох зүйлсийг дурдаж, энэ нь ямар бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой болохыг тайлбарлана.

Үр дүнгийн үзүүлэлтийг хангахад нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйлүүд тухайлбал, орон тоо, бусад гол орц /зардлын зүйлс/-ууд г.м. зүйлсийн талаар дурдаж, зарлага нь орон тооны хандлага, гүйцэтгэлтэй яаж уялдаж буйг тайлбарлана. Тодорхой зарлагын өсөлт анхаарал татах хэмжээнд хүртэл өөрчлөгдөж байгаа бол энэ нь юунаас болж өөрчлөгдөж буйг орц болон бүтээгдэхүүний гүйцэтгэлтэй уялдуулж тайлбарлах. Зардалд гол нөлөө үзүүлж буй хүчин зүйлс /зардал чиглүүлэгчид/ болон зардал, гарц /бүтээгдэхүүн, үйлчилгээ/ болон хөтөлбөрийн хоорондын уялдааг, дүн шинжилгээний хамт танилцуулах. Энэ хэсгийг дунджаар 2 хуудаст багтаан бичвэл зохимжтой. Дээрх хөтөлбөр, үр дүнгийн танилцуулгыг бичихэд дараах зүйлсийг харгалзан үзэх:

- (a) Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хангахад дунд хугацаанд төсвийн зарцуулалт аль хөтөлбөр, бүтээгдэхүүнд голлон чиглэж буй талаар товч дурдах;
- (b) Тодорхой гарц /бүтээгдэхүүн, үйлчилгээ/ хангахад гол хөтөлбөр болон зарлагын чиг хандлага, хүний нөөц болон бусад орц хэрхэн хувь нэмэр оруулах талаар дурдах;
- (c) Засгийн газраас баталсан хязгаар нь гарцыг нийлүүлэхэд хэрхэн нөлөөлөх вэ, суурь түвшинд гарах өөрчлөлт, тэрхүү өөрчлөлт гарахад хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлж оруулах;
- (d) Тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан гол хөтөлбөр болон орцын хувьд хангалтгүй хэмжээний төсөв хуваарилагдсан шалтгааныг тайлбарлах, дутагдсан санхүүжилт гарцын үзүүлэлтэд ямар нөлөө үзүүлсэн болон үүнийг ирэх жилийн төсвийн хувьд хэрхэн засаж, залруулах талаар оруулах;
- (e) Хүний нөөцийн болон бусад томоохон орцуудын өсөлтийн хувьд гарч буй өөрчлөлтийг дунд хугацааны төсвийн хүрээнд тайлбарлах.

4.1.10 Төсвийн хязгаараас давсан саналын үндэслэл, тайлбар, нотолгоог **ТМ-01** маягтын “Ж” хэсэгт товч тодорхойлсон байх. Хязгаараас давсан хэсгийн санхүүжилтийг ямар эх үүсвэрээс шийдвэрлэх ба ингэхдээ маягтын “З” хэсэгтэй уялдсан байдлаар тодорхойлох;

4.1.11 Нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдол бага гэж үзэж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах саналтай бол, түүнчлэн санхүүжилтийг нь бууруулах болон зогсоох хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлтийг юунд зарцуулах тухай саналаа **ТМ-01** маягтын “З” хэсэгт товч тодорхойлсон байх.

4.2 Төсвийн үндсэн маягтын нэмэлт буюу ТМ-01а

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүн, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх. ТЭЗ нар хүрэх үр дүнг тодорхойлохдоо “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан холбогдох хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг харгалзан үзнэ. Хэрэв “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тухайн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй бол хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг батлагдсан төсвийн хязгаарт багтаан тооцож, тодорхойлно. Ингэхдээ нэг хөтөлбөрт 3-с дээшгүй үр дүнг тодорхойлохыг анхаарна уу.

Түүнчлэн үр дүн болон шалгуур үзүүлэлт тодорхойлох аргачлалыг 1.2_ТМ-01а маягт бөглөх заавар - аас танилцана уу.

4.3 Төсвийн удирдамжид дагалдсан төсвийн маягтуудын товчоо

Хүснэгт 5. Төсвийн саналын нэмэлт маягтууд

Маягтын нэр	Хүснэгтийн код	Маягт болон хүснэгтийн агуулга
1.1_Төсвийн саналын маягт	НМ-01	ТЭЗ-ийн харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлогын санал
	НМ-02	ТЭЗ-ийн төсвийн урсгал зарлагын саналын товчоо
	НМ-03	ТЭЗ-ийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн санал
	НМ-04	ТЭЗ-ийн шинээр ашиглалтад орох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбогдон гарах урсгал зардлын тооцоо
	НМ-05	ЭМД-ын шимтгэлийг нь төрөөс хариуцан төлөх иргэдийн тооцоо
	НМ-06 (ОН) НМ-06а (ОН) НМ-06 (УТ) НМ-06а (УТ)	Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдагчдын судалгаа
	НМ-07 НМ-07а НМ-07б НМ-07в	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн судалгаа
	НМ-08	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн тэтгэмж авах албан хаагчийн судалгаа
	НМ-09	ТЭЗ-ийн Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал

	НМ-10 НМ-10а	ОН-ийн сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмжийн судалгаа
	НМ-11а НМ-11б	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилалд тусгах арга хэмжээний судалгаа, зардлын задаргаа
	НМ-12 НМ-12а НМ-12б НМ-12в НМ-12г НМ-12д	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын судалгаа
1.2_ТМ-01а маягт бөглөх заавар		ТМ-01а маягтыг бөглөх заавар
2.1_ҮДСТ төсвийн саналын маягт_УТ		ГБХНХЯ, ХХААХҮЯ, СПАЖЗЯ, БЯ-ны ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөв боловсруулах маягт
2.2_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар_УТ		ГБХНХЯ, ХХААХҮЯ, СПАЖЗЯ, БЯ-ны ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөв боловсруулах маягт бөглөх заавар
3_Fiscal-B гарын авлага		Fiscal – В гарын авлага
4_Төсвийн саналын товч танилцуулга		Олон нийтээр хэлэлцүүлэх асуудлаар төсвийн саналын товч танилцуулга бэлтгэх загвар

4.4 Бусад

- 4.4.1 Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх;
- 4.4.2 Ажлын ачааллыг нягтруулах замаар одоо мөрдөгдөж байгаа орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталж, орон тоо, цалингийн санг төлөвлөх;
